

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№24

ШУС, НУС

2023

**МОНГОЛ ХЯТАД ХОЁР УЛСЫН МОНГОЛ БИЧГИЙН ЗӨВ БИЧЛЭГИЙН
ТОЛЬД АЖИГЛАГДСАН СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ЧИГ
БАРИМЖААГ ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ**

Сэцэн*, Уяхан**

*БНХАУ-ын ӨМИС-ийн Монгол судлалын дээд сургуулийн Сонин мэдээ, хэвлэлийн ухааны тэнхимийн профессор, доктор (Ph.D) (010021)

**БНХАУ-ын ӨМИС-ийн Монгол судлалын дээд сургуулийн Сонин мэдээ, хэвлэлийн ухааны тэнхимийн магистрант

Түлхүүр үгс: монгол бичиг, зөв бичлэгийн толь, соёлын үнэт зүйлс, зохиогч, зохиогчийн намтар, нийгмийн байр суурь, үүрэг хариуцлага

Энэхүү өгүүлэл нь БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны суурь судалгааны төсөл болох “Монгол бичгийн сурвалжид суурилсан дэлгэрэнгүй утгын зөв бичлэгийн дүрмийн судлал” (Зөвшөөрсөн № 19VJX117)-ын хүрээнд бичигдсэн бүтээл болно.

Өгүүлэлд монголчуудын мянгаад жилийн уламжлалт соёлын тээгч болсон монгол бичгийн зөв бичлэгийн ёсон хийгээд нэг улс үндэстний тухайн цаг үеийн ном хэвлэлийн чанар чансааг төлөөлж чадахуйц хэвлэгдэхүүн болох толь бичиг болон түүнийг найруулан хэвлүүлэх ажилд илэрсэн Монгол, Хятад хоёр улсын нийгэм түүхийнх нь соёлын үнэт зүйлсийн чиг баримжаа (Cultural values orientation – “Соёлын үнэт зүйлсийн чиг баримжаа” буюу “Соёлын үнэ цэний чиг хандлага”-тай утга дүйнэ)-г харьцуулан судлав. Хоёр улсын монгол бичгийн зөв

бичлэгийн толиос нийт найман толь бичгийг сонгон авч эх хэрэглэгдэхүүн болгосон билээ. Эдгээр толь бичгийн дахин хэвлэсэн тодорхойлолт, оршил, өмнөтгөл, удиртгал, толь ашиглах заавар, гаргалгаа, хэвлэлийн эрхийн хуудас (хэвлэн нийтлэлийн нүүр) зэрэг дагалт зохиолоос толийн нэрийдэл, зохиогч найруулагч, хэвлэсэн он, хэвлэсэн газар, үсгийн төрөл, гарчгийн байршуулалт, бичлэгийн дүрэм, хавсралт, ном зүй зэрэг бар хэвлэлийн есөн зүйлийн үндсэн мэдээлэл ба толгой үгийн тоо, дараалал, нэгжлэлийн баримжаа, төрөлжүүлэлт, үгсийн аймаг, тайлбар, хөдлөх үндэс, дуудлага хадалт, ормол үгийн гарал хийгээд бичлэг зэрэг есөн талын найруулах аргад ажиглагдсан Монгол, Хятад хоёр улсын соёлын үнэт зүйлийн чиг баримжааны ялгааг хам ба цуваа цагийн үүднээс харьцуулан судлав. Бид тус судалгааны үзэлтээ дараах 17 зүйлээр нэгтгэн дүгнэв.

Толь бичгийн нэрийдэлд ажиглагдсан тусгайлаг соёлтон ба ерөнхийлөг соёлтны соёлын үнэт зүйлсийн чиг баримжааны ялгаа.

Монголд хэвлэгдсэн 1937 оны “Монгол үсгийн дүрмийн толь бичиг” (Цаашид “Шагжийн толь” гэж товчлов), 1992 оны “Монгол бичгийн хадмал толь” (Цаашид “Хадмал толь” гэж товчлов), 2013 оны шинээр журамласан “Монгол бичгийн зөв бичих зүйн толь” (Цаашид “Шинээр журамласан толь” гэж товчлов), 2020 оны нэмж засварласан “Монгол бичгийн зөв бичих зүйн толь” (Цаашид “Нэмж засварласан толь” гэж товчлов) зэрэг дөрвөн толийн нэрийдэлд монгол бичгийн зөв бичих зүйн бичгийн хэлээр судлагдахуун болгосон ба бичлэгийн дүрмийг судалснаа тодорхой тусгасан бөгөөд зөв бичлэгийн онолын асуудлыг хөндөхийг чухалчилснаараа шинжлэх ухаанч болсон давуу талтай. Гэтэл Хятадад хэвлэгдсэн 1977 оны “Монгол хэлний зөв дуудлага зөв бичлэгийн толь” (Цаашид “Бүрэнтөгсийн толь” гэж товчлов), 1999 оны дээд, доод ботио “Монгол зөв бичлэгийн толь” (Цаашид “Хятадын нэг дэх хэвлэл” гэж товчлов), 2012 оны нэмж зассан “Монгол зөв бичлэгийн толь” (Цаашид “Хятадын хоёр дахь хэвлэл” гэж товчлов), 2020 оны гурав дахь хэвлэл хэмээх “Монгол зөв бичлэгийн толь” (Цаашид “Хятадын гурав дахь хэвлэл” гэж товчлов) зэрэг дөрвөн толийн нэрийдэлд “монгол хэлний” хэмээх харьяалсан тодотгол ба “монгол” гэсэн хэт ерөнхий, нэрлэсэн тодотголыг хэрэглэсэн нь монгол бичгийн зөв бичлэгийн толийн бичгийн хэлний үзэгдлээр судлагдахуун болгох хүрээ хэвчээний ойлголт нь тодорхой биш буюу судалгааны хүрээндээ нэгдсэн ойлголтгүй бөгөөд ярианы хэлийг нэн түлхүү авч үздэгийг харуулжээ. “Монгол зөв бичлэгийн толь” хэмээх нэрийдэлд монгол бичгийн зөв бичлэгийн толиос гадна кирилл, тод,

вагиндра, соёмбо, дөрвөлжин зэрэг монгол төрлийн бусад бичгийн зөв бичлэгийн толиудыг бүгдийг багтаадаг. Гэтэл Хятадад хэвлэгдсэн толь бичгүүдэд судлагдахуунаа нарийн тодорхойлоогүйд аливаа зүйлийн олон чадамжийг эрхэмлэдэг ерөнхийлөг соёлтны онцлог илэрчээ.

Зохиогч найруулагчийн биеийн гаралд тусгагдсан бодгальч үзлийн соёлтон ба хамтач үзлийн соёлтны үнэт зүйлсийн чиг баримжааны ялгаа. Монгол, Хятад хоёр улсын монгол бичгийн зөв бичлэгийн толийг зохиож найруулсан хүмүүсийн товч намтар нь эрс ялгаатай. Тухайлбал, Монголд хэвлэгдсэн толийг монгол бичгийн зөв бичлэгийн судалгаа шинжилгээ болоод найруулах хэвлэх ажилд мэргэшсэн бодгальцогц буюу хувь хүн зохион найруулжээ. Харин Хятадад хэвлэгдсэн анхны толийн зохиогч алдарт тольч, ахмад найруулагч Бүрэнтөгсийг эс тооцвол дараагийн гурван хэвлэлийнх нь найруулагч нь их, дээд сургуулийн профессор багш, Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн эрдэмтэн судлаач, хэвлэлийн газрын нэр төртэй найруулагч редактор хийгээд засаг захиргааны эрх мэдэл бүхий албан тушаалтнаас бүрдсэн “Монгол зөв бичлэгийн толь” найруулах комисс хэмээх нэгдсэн баг бөгөөд гишүүд нь нийгмийн байр суурь, ажил үүрэг, эрх мэдлийн онцлогоос шалтгаалан хэвлэл болгонд солигддог. Хятадын тольд хариуцан хэвлүүлэгчдийн хамт нийтийн нөлөө тусгалыг чухалчлан комиссынхоо нийгмийн байр суурийг тасралтгүй дээшлүүлсэн боловч тус толь нь нийгэм нийтэд зөв буруу, элдэв эснээр шүүмжлэгдэх үес уншигч хэрэглэгчдэд хариу тайлбар өгч хариуцлага хүлээгсэд нь өдрийн од

шиг цөөн. Комиссын гишүүдээс нь дүрэмжүүлсэн үндэслэлийг тодруулахад “Олноороо хэлэлцэж тогтсон дүн, ганц хоёрхон хүний үзэл бодол биш” гэж хариулдаг. Харин Монголд хэвлэгдсэн толийн зохиогч, найруулагчид нь нэрт тольч Шагж, эрдэмтэн багш Чой.Лувсанжав, Шарайд Г.Гантогтох, Боржигин Дармаабал, монгол бичгийн найруулах ажилд мэргэшсэн, шинэ үеийн шалгарсан найруулагч Нямсүрэнгийн Даш, Бямба-Очирын Одончимэг, Содномын Чулуунпүрэв нар болно. Ерөнхийдөө Монголын толийн найруулагчид нийгмийн байр суурь, зэрэг цол, нас хүйсийн ялгад хязгаарлагдаагүйгээр үл барам хариуцан хэвлүүлсэн монгол бичгийн зөв бичлэгийн толийнхоо уламжилж, шинэчилсэн агуулгадаа маш тодорхой ойлголттой байж, зөв бичлэгийн толь найруулах ажлыг эрх тушаалаар биш, үүрэг хариуцлагаар хүлээн авсан бодгальч үзлийг эрхэмлэдэг соёлын үнэт зүйлсийн чиг баримжааг харуулжээ. Монголд хэвлэгдсэн толийн адил бус хэвлэлүүдийн зохиогч нь бодгаль хүн, агуулгын шинэчлэлт нь ч тов тодорхой байхад Хятадад хэвлэгдсэн “Бүрэнтөгсийн толь”-оос бусад гурван толийн зохиогчдын баг бүрэлдэхүүнийг засаг захиргааны талаас сонгон томилсон байх бөгөөд тус комиссынх нь нэр нь хэвээр боловч, гишүүд нь солигдож өөрчлөгдсөн байдал түгээмэл ажиглагддаг. Гишүүд нь хамгийн их өөрчлөгдсөн “Хятадын гурав дахь хэвлэл”-ийн агуулга нь шинэчлэлтийн хувьд хамгийн тодорхой бус болжээ. Иймээс Хятадад хэвлэгдсэн толиудын хувьд авч үзвэл, найруулах комиссын гишүүдийг өөрчлөн солиход анхаардгийн нэгэн адилаар толь бичгийн чансааг нь дээшлүүлж, агуулгыг нь төгөлдөржүүлэхийг чухалчлах нь зүй-

тэй. Учир нь толь найруулах ажилд оролцох хүний тооноос илүүтэйгээр тухайн толь бичгийг чанаржуулах нь нэн чухал билээ.

Хэвлэж нийтэлсэн цагийн тодорхойлолтод ажиглагдсан ил цагийн хэвшилт соёлтон ба далд цагийн хэвшилт соёлтны үнэт зүйлсийн чиг баримжааны ялгаа. Монголд хэвлэгдсэн толийн хэвлэлүүдэд нийтэлсэн хугацаагаа он хүртэл нь тавихаас бус сар, өдрийг нь нарийвчлан тэмдэглэдэггүй. Харин Хятадад хэвлэгдсэн толийн хэвлэлүүдэд хэвлэлд шилжүүлсэн болон нийтэлсэн хугацаагаа бүр он сараар нь ялган тодорхойдог. Монголд хэвлэгдсэн толийн нийтэлсэн хугацааны тодорхойлолтод хүн төрөлхтөнд адилхан мэдрэгдэн ойлгогддог байгальлаг цаг болох оноор нэгжилснийг ил цагийн хэвшилт соёлын үнэт зүйл гэж үзэхэд хүрвэл, Хятадад хэвлэгдсэн толийн сараар нэгжилсэн хоёр зүйлийн цагийн тодорхойлолтыг далд цагийн хэвшилт соёлын үнэт зүйлийг илтгэсэн хэмээн ойлгож болно.

Хятадад хэвлэгдсэн толийн хоёр зүйлийн цагийн тодорхойлолтод хэвлэлийн газар ба дармалын үйлдвэрийн толийг бүтээх явц дахь ажлын дараалал ба үүрэг хариуцлагын ялгааг товойлгосон бол, сараар нэгжилсэн тодорхойлолтод хэвлэлийн байгууллага ба дармалын үйлдвэрийн ном хэвлэлийн үелэлт хугацааны харьцангуй богино болохыг илтгэсэн “Эхийг нь ч эцээхгүй, тугалыг нь ч тураахгүй” байхыг сурталчилдаг бичгийн сургаалын “Хэв дунд”-ыг баримталдаг соёлын үнэт зүйл илэрч буй.

Ажил үйлсийн нэгжийг эрхэмлэдэг хамтач үзлийн соёлтон ба аж ахуйллын нэгжийг эрхэмлэдэг бодгальч үзлийн соёлын үнэт зүйлсийн

чиг баримжааны ялгаа. Монголд хэвлэгдсэн дөрвөн толийн хэвлэж түгээсэн газрын тодорхойлолтод хэвлэлийн эрх бүхий ганцхан байгууллагыг бичдэг бөгөөд тэдгээрийн өмнөх хоёр нь ажил үйлсийн нэгж (төрийн байгууллага), сүүлийн хоёр нь аж ахуйллын нэгж (хувийн хэвшлийн байгууллага) байж хөгжилтийн чиг хандлага нь ихэвчлэн аж ахуйллын байгууллага байдаг. Үүнд бас тухайн байгууллагын хаягийг багаас их, бодитойгоос хураангуйн дарааллаар бичдэг. Иймэрхүү хаяглалын хэвшилд асуудлыг сэтгэж шийдвэрлэхдээ бодитойг эрхэмлэдэг соёлын үнэт зүйл илэрч буй. Хятадад хэвлэгдсэн тольд ажил үйлсийн нэгжээр голлосон олон байгууллагын нэр бичдэг боловч тэдгээрийнхээ оршин буй байршлын хаягийг нарийн тодорхой тэмдэглэдэггүй. Энэ нь нэг ажилд олон байгууллага оролцдог, хамтын ажлыг эрхэмлэдэг хамтач үзлийн соёлын үнэт зүйлийн гол шинж чанарыг харуулж буй.

Үсгийн төрөл хийгээд түүний байршлын хувиралтад ажиглагдсан олон эшт соёлтон ба дангааршил соёлын үнэт зүйлсийн чиг баримжааны ялгаа. Хятадад хэвлэгдсэн монгол бичгийн зөв бичлэгийн толийн бүх агуулга нь дан цулгүй монгол бичгээр бичигдсэн дангааршил соёлтны онцлогийг харуулсан байхад Монголд хэвлэгдсэн “Шагжийн толь”-ыг эс тооцвол нөгөө гурван зөв бичлэгийн толийг монгол бичиг ба кирилл үсгээр бичжээ. Энэ нь монгол бичгээрээ найруулан хэвлэж байснаа болиод кирилл, монгол хоёр бичгийг хослуулан хэрэглэх болсон бичгийн соёлын олон янзын чанартайг харуулж буй. Монгол бичгийн хэвшлээр босоогоор найруулж байснаа

болиод кирилл үсгийн хэвшлээр хөндлөн чиглэлээр найруулж хэвлэх болсон сүүлийн үеийн хоёр хэвлэлд толгой үгээс бусад тайлбар, жишээ хийгээд дагалт зохиолоо бүгдийг кирилл үсгээр бичдэг болжээ. Энэ мэт үсгийн төрөл хийгээд бичлэгийн хэвшлийн хувиралтаас шалтгаалан Монголд хэвлэгдсэн толийн монгол бичгээрээ гол болгох соёлын үнэт зүйл нь алгуураар суларсаар гагцхүү толгой үгийн хадмалд л “Утсан чинээ улаан амь нь” оршиж буй нь ажиглагдана.

Толь бичгийн гарчиг найруулахад ажиглагдсан зөв бичлэгийн толь найруулагчийн мэдлэг боловсролын зөрүү. Монголд хэвлэгдсэн монгол бичгийн зөв бичлэгийн толиудад олон дэгтэрлэсэн ганцхан гарчигтай байхад, Хятадад хэвлэгдсэн толиудын гарчиг тийм биш. Даруй ерөнхий гарчиг ба хавсралтын гарчиг гэсэн хоёр гарчиг тавьсан байдаг. Энэ нь Хятадад хэвлэгдсэн зөв бичлэгийн толийн найруулагчид нэг хэвлэгдэхүүн нэг л гарчигтай байдаг ном найруулах ухааны уг ёс ба дэгтэрлэсэн гарчиг найруулж болох арга зүйг баримтлаагүйгээс болжээ. Дагалт зохиолын найруулсан аргад нь бас мэргэжлийн бус хийгээд дүрэмжилгүй байдал зих байна. Эдгээр нь Хятадын монгол бичгийн зөв бичлэгийн толь найруулагчийн мэдлэг боловсролтой салшгүй холбоотой.

Толгой үгийн төрөлжүүлэлттэй зөв бичлэгийн толь хийгээд хоёроос дээш дагалт зохиолтой зөв бичлэгийн тольд гарчиг тавих нь зүйн хэрэг боловч, аливаа толь нь олон дэгтэрлэсэн нэг л гарчигтай байх нь толь хэрэглэгчдэд илүү үр өгөөжтэй. Иймээс Монголын толийн гарчиг

найруулах арга туршлагаас бид санаа аван суралцвал зохино.

Зөв бичлэгийн дүрмийн тайлбар хийгээд түүний байршуулалтад тусгагдсан зөв бичлэгийн онолын судалгааг чухалчилсан эсэхийн ялгаа.

Монголд хэвлэгдсэн дөрвөн толийн алинд нь ч монгол бичгийн зөв бичлэгийн дүрмийн агуулга бүр байдаг. Энэ нь зөв бичлэгийн толийн онолын үндэслэлийг ихэд чухалчилсныг харуулж буй. Харин Хятадад хэвлэгдсэн толийн эхний хоёр хэвлэлд бичлэгийн дүрмийг тайлбарлаагүй байсан бол, удаах хоёр хэвлэлийн хавсралтад зөв бичлэгийн дүрмийг нэмж оруулжээ. Гэхдээ тун явцуу хүрээнд буюу үндсэн үгийн бичлэгийн судалгаан дээр эргэлдсээр байна. Цэгцлэн дүрэмжүүлбэл зохих тоо бичлэгийн асуудлыг хөндөөгүй байна. Зээллэг үг ба оноосон нэрийн бичлэгийг хөндсөн боловч бичлэгийн дүрэм нь төдий л нарийсан гүнзгийрээгүй зэрэг дутагдал ажиглагдаж буй. Иймээс Хятадад хэвлэгдсэн зөв бичлэгийн толийн найруулагчид эртнээс эдүгээг хүртэл тасралтгүй хэрэглэсээр ирсэн монгол бичгийнхээ

зөв бичлэгийн ёсны судалгааны хүрээ хэвчээгээ тэлэх хэрэгтэй бөгөөд Монголын зөв бичлэгийн толь найруулагчдаас санаа аван суралцаж ормол үг, тоо бичлэг, оноосон нэрийг багтаасан нийлмэл үгээс авхуулаад дагавар, нөхцөл хүртэл өргөтгөн монгол бичгийн хэлний нэгжийг тогтолцоонд нь гүнзгийрүүлэн судлах орон зай их байна.

Зөв бичлэгийн толийн толгой үгийн тооны тодорхойлолтод тусгагдсан арга соёлтон ба билиг соёлын үнэт зүйлсийн ялгаа. Хятадад хэвлэгдсэн монгол бичгийн зөв бичлэгийн дөрвөн тольд толгой үгийн тоог нийдэм чухалчлан толийн жишиг (хэрэглэх заавар)-ийн эхний зурваст тодорхойлог. Харин Монголд хэвлэгдсэн монгол бичгийн зөв бичлэгийн өмнөх хоёр тольд толгой үгийн тоог маш чухалчлан номын дотор хавтсанд бичсэн байдаг боловч сүүлийн хоёр тольд толгой

үгийн тоог нарийвчлан тэмдэглэсэнгүй. Гэхдээ толгой үгийн хувиллыг системтэйгээр нэг доор тайлбарлахыг чухалчлах болжээ. Ийнхүү Монголд хэвлэгдсэн тольд чанарыг эрхэмлэдэг

«

“Шагжийн толь” дахь толгой үгээ жагсаасан монгол бичгийн цагаан толгойн дараалал ба Хятадад хэвлэгдсэн дөрвөн толь дахь монгол бичгийн цагаан толгойн дараалал нь ихээхэн ялгаатай байна. ... Монголд хэвлэгдсэн сүүлийн гурван тольд толгой үгийг кирилл үсгийн цагаан толгойн дарааллаар жагсаасан нь нэг талаараа кирилл үсгээр эхэлж бичиг сурсан, түүнчлэн монгол бичгээ анх сурч хэрэглэж байгаа Монгол Улсын монголчуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн “Хэрэглэгч хаан гэх” хандлага дээр суурилсан нь илт. Энэ нь Монголын хүлээн авагчийн толь ашиглахад илүү амар хялбар байх талыг харгалзан үзсэнээс үүдэлтэй боловч, нөгөө талаараа монгол бичгээ шинжлэх ухаанчаар сурч хэрэглэхэд тун ашиггүй дараалал хэмээн үнэлж болохоор байна

»

билиг соёлын үнэт зүйл илэрч буй бол Хятадад хэвлэгдсэн тольд тоог чухалчилдаг арга соёлын үнэт зүйл ажиглагддаг.

Толгой үгийн жагсаалтын дараалалд тусгагдсан монгол бичгийн зөв бичлэгийн толийн зорилтот хүлээн авагчийн ялгаа. “Шагжийн толь” дахь толгой үгээ жагсаасан монгол бичгийн цагаан толгойн дараалал ба Хятадад хэвлэгдсэн дөрвөн толь дахь монгол бичгийн цагаан толгойн дараалал нь ихээхэн ялгаатай байна. Монгол Хятад хоёр улсад монгол бичгийн цагаан толгойн дарааллын эрс ондоо байдлаар хэрэглэгдэх болсны шалтгааныг гүнзгийрүүлэн судлууштай. Монголд хэвлэгдсэн сүүлийн гурван тольд толгой үгийг кирилл үсгийн цагаан толгойн дарааллаар жагсаасан нь нэг талаараа кирилл үсгээр эхэлж бичиг сурсан, түүнчлэн монгол бичгээ анх сурч хэрэглэж байгаа Монгол Улсын монголчуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн “Хэрэглэгч хаан гэх” хандлага дээр суурилсан нь илт. Энэ нь Монголын хүлээн авагчийн толь ашиглахад илүү амар хялбар байх талыг харгалзан үзсэнээс үүдэлтэй боловч, нөгөө талаараа монгол бичгээ шинжлэх ухаанчаар сурч хэрэглэхэд тун ашиггүй дараалал хэмээн үнэлж болохоор байна. Иймээс Монгол Хятад хоёр улсын монгол бичгийн зөв бичлэгийн толийн толгой үгийг монгол бичгийн хэлний дуудлагын дагуу, цагаан толгойн шинжлэх ухаанч дарааллаар жагсаан найруулбал зохино.

Толгой үгийн нэгжлэлд тусгагдсан монгол бичгийн зөв бичлэгийн ёсон дахь дуудлага ба утгын үйлдлийн ойлгогдохууны ялгаа. “Шагжийн толь”-ийг эс тооцвол

Монголд хэвлэгдсэн толиудад толгой үгийг ярианы дуудлагаар нэгжлэн жагсааснаас шалтгаалан ямар ч утгын холбоогүй хэд хэдэн үгс (^{ᠬᠠᠷᠠ} [hara], ^{ᠬᠠᠷᠠ} [har_a], ^{ᠬᠠᠷᠢ} [harv], ^{ᠬᠠᠷ} [har])–ийг нэг толгой үгэнд араб тоо эсвэл ром тоогоор дугаарлан дэд толгой үг болгон оруулсан байдаг. Энэ нь монгол бичгийн зөв бичлэгийн ёсонд үзүүлэх ярианы хэлний дуудлагын нөлөөг хэт чухалчилсан шинжлэх ухаанч бус хэвшил болно. Харин Хятадад хэвлэгдсэн тольд бичгийн хэлний дуудлага хийгээд утгын ялгаанд тулгуурлан дан үгээр нэгжилж толгой үг жагсаахыг хичээсэн нь илүү оновчтой болжээ.

Толгой үгийн төрөлжүүлэлтэд тусгагдсан зөв бичлэгийн судалгааны явцуу дэлгэрэнгүй хүрээ хэвчээний ялгаа. Хятадад хэвлэгдсэн монгол бичгийн зөв бичлэгийн тольд толгой үгийг ер нь төрөлжүүлдэггүй, хавсралтдаа оноосон нэр ба ормол үгийг сонголттойгоор хүснэгтжүүлэн дагалдуулдаг. Харин Монголд хэвлэгдсэн “Шагжийн толь”-оос бусдад нь толгой үгийг үндсэн үг, ормол үг, хүний нэр, газрын нэр гэхчлэн төрөлжүүлдгээр барахгүй тэдгээр төрлийн толгой үгээ үндсэн үгтэйгээ зэрэгцүүлэн жагсаадаг болжээ. Гэхдээ ормол үг ба нийлмэл үгийг Монголд хэвлэгдсэн толь шиг тус тусад нь толгой үгээр төрөлжүүлэн жагсаах уу? Аль эсвэл Хятадад хэвлэгдсэн толь шиг толгой үгийг төрөлжүүлэхгүйгээр нийлүүлэн жагсаах уу? гэдгийг зорилтот хүлээн авагчаа тодорхойлсны үндсэн дээр тогтоовол зохино.

Зөв бичлэгийн толийн толгой үгийн жагсаалтад үндсэн үг, ормол үг, оноосон нэр бүгдийг багтаасан нөхцөлд төрөлжүүлэхгүйгээр монгол бичгийн цагаан толгойн шинжлэх

ухаанч дарааллаар жагсаах нь мэргэжлийн бус энгийн хэрэглэгчдийн толь ашиглахад илүү амар хялбар байдаг бол, толгой үгийг төрөлжүүлэх нь үгийн гарлаа мэддэг мэргэжлийн хэрэглэгчдэд үр өгөөжтэй байдаг. Гэвч Монголд хэвлэгдсэн толь шиг эртэвтэр авч хэрэглэсэн ормол үгээ үндсэн толгой үгэнд багтаан, сүүлийн үед орж ирсэн ормол үгийг тусад нь жагсаахад хүрвэл мэргэжлийн ба мэргэжлийн бус хэрэглэгчдийн алинд нь ч үр өгөөжгүй болно. Иймээс Монгол Хятад хоёр улсын монгол бичгийн толь найруулагчид зорилтот хэрэглэгчдээ тогтоосны дараа нэг бол толгой үгийг бүрэн гүйцэд төрөлжүүлэн мэргэжлийн хэрэглэгчдэд зориулсан толь зохионо. Нөгөө бол толгой үгийг үндсэн үг, ормол үг гэх мэтчилэн төрөлжүүлэхгүйгээр бүх толгой үгийг монгол бичгийн цагаан толгойн дарааллаар жагсаагаад мэргэжлийн бус хэрэглэгчдэд зориулсан толь зохиох болно.

Толгой үгийн үгсийн аймгийн тодорхойлолтод ажиглагдсан үг зүйн зарчмын ойлгогдохууны ялгаа. Хятадад хэвлэгдсэн толиудаас “Бүрэнтөгсийн толь”-д толгой үгийн үгсийн аймгийг тодорхойлоогүйг эс тооцвол, бусад гурван хэвлэлд үгсийг аймаглан ялгажээ. Анхлан арван аймагт хувааж байснаа сүүлийн үед арван гурван аймагт хуваах болж үгсийн аймгийн хуваарилалтаа улам бүр нарийвчлан гүнзгийрүүлсэн байна. Гэвч Монголын зөв бичлэгийн бүх тольд толгой үгийн үгсийн аймгийг ялган тодорхойлсонгүй. Энэ нь үгийн зүйн зарчмын агуулга хийгээд түүний монгол бичгийн зөв бичих зүй дэх захирах хүчинд бүрэн ойлголтгүйг харуулж байна. Өөрөөр хэлбэл, монгол бичгийн зөв бичлэгийн ёсны

үгийн зүйн зарчимд үгийн бүтээврийн бүтцийг эвдэхгүй байхыг баримтлах агуулга байхаас гадна, бас тухайн үгийн үгсийн аймгийн ялгалд үндэслэн үгсийн бүрэлдэхүүнээрээ адил үгсийг ялгаатай бичихийг хичээдэг агуулга ч бий юм. Иймээс зөв бичлэгийн толийн толгой үгийн үгсийн аймгийг тодорхойлох нь үгийн бүрэлдэхүүнээрээ ижил боловч утга ондоо үгсийг өөр өөр толгой үгээр жагсаах, тухайн үгийн бичгийн хэлний дуудлага хадах, үгийн сангийн нэгжийг гүйцэд тодруулах ба адил үгсийн бүрэлдэхүүнт үгс (Жишээлбэл: “Пад (ᠯᠠᠳ) харанхуй шөнө” ба “Трактор пад пад (ᠯᠠᠳ ᠯᠠᠳ) хийх” мэт)-ийн бичлэгийн дүрсийг ялгаатай байлгах зэрэгт тусална.

Толгой үгийн хөдлөх үндсийн тодорхойлолтын байршилд тусгагдсан хэлэхүйн орчны ойлгогдохууны ялгаа. Хятадад хэвлэгдсэн тольд эгшгээр төгссөн үүсмэл ба үүсмэл бус нэр үгийн зарим нь хөдлөх үндэстэй үг болохыг тухайн толгой үгийнхээ дараах хаалтад тусгайлан тодорхойлдог билээ. Харин Монголд хэвлэгдсэн эхний хоёр тольд нэр үгийн хөдлөх үндсийг огт ялган тодорхойлоогүй байсан бол сүүлийн хоёр толь болох “Шинээр журамласан толь” ба “Нэмж засварласан толь”-ийн толгой үгийн тайлбарт хөдлөх үндэстэй үгийг харьяалах, өгөх орших, гарахын тийн ялгалд үндэс нь хөдлөөд “-н” дэвсгэртэй болж бичигддэгийг улаан өнгөөр онцлон тодосгох болжээ. Хөдлөх үндэстэй нэр үг нь хэлэхүйн орчинд бодитойгоор хэрэглэгдэх үед л үндэс нь хөдөлдөг тул, Хятадад хэвлэгдсэн толийн найруулагчид Монголд хэвлэгдсэн толийн толгой үгийн тайлбарын үг зүйн хувиллын тодорхойлолтодоо улаан өнгөөр онцлон тодосгон шийдвэрлэсэн сүүлийн үеийн арга

туршлагаас бүтээлчээр суралцвал зохино.

Толгой үгийн тайлбарт тусгагдсан зөв бичлэгийн толийн өвөрмөц онцлогийг тодруулсан эсэхийн ялгаа. Хятадад хэвлэгдсэн тольд толгой үгийн утгын тайлбарыг чухалчилсан байдаг бол, Монголд хэвлэгдсэн тольд толгой үгийн хэлний зүйн хувиллын бичлэгийн дүрсийг хэлэхүйн орчинд нь бодитойгоор тусгахыг хичээжээ. Монгол бичгийн зөв бичлэгийн тольд толгой үгийн утгын тайлбарыг товч бөгөөд тодорхой ойлгомжтой байлгах зарчмыг баримтлан: Нэгд, ганц хоёр үгээр тайлбарлаж болох толгой үгэнд дахин жишээ хадсаны хэрэг алга. Хоёрт, толгой үгийн утгыг жишээгээр тайлбарлах бололцоотой нөхцөлд утгын тайлбар нэмж хийх шаардлагагүй. Гуравт, толгой үгийн салбарласан утгыг Монголд хэвлэгдсэн сүүлийн үеийн хоёр хэвлэлийнх шиг хаалтад товч авсаархан тайлбарлана. Дөрөвт, монгол бичгийн зөв бичлэгийн толийн өвөрмөц онцлогийг тодруулахад утгын тайлбараас илүүтэйгээр тухайн толгой үгийн хэлний зүйн хувиллын бичлэгийн дүрсийн хувиралтыг тогтолцоотойгоор тусгасан хэлний зүйн тайлбар нэн чухал. Энэ талаар мөн ч Хятадад хэвлэгдсэн толийн найруулагчид Монголын зөв бичлэгийн толь найруулагчдын туршлагаас суралцвал зохино. Гэвч Монголд хэвлэгдсэн тольд кирилл үсгээр бичдэг толгой үгийн утгын тайлбар хийгээд хэлний зүйн хувиллын хэлбэрийг монгол бичгээрээ бичихийг алхам дараатайгаар гүйцэтгэвэл зохино. Монголын тольд зөв бичлэгийн толийн өвөрмөц онцлогийг чухалчилснаараа Хятадын зөв бичлэгийн толиос давуу боловч, монгол бичгээрээ тайлбарлаж жишээлэх

талаар Хятадын зөв бичлэгийн тольд хүрэхгүй байгаа нь ажиглагдана.

Толгой үгийн дуудлага хадалтад ажиглагдсан монгол бичгийн зөв бичлэгийн ёсны судлагдахууны шинж чанарын танилтын зөрөө. Монголд хэвлэгдсэн дөрвөн тольд толгой үгийн бичгийн хэлний дуудлагыг ерөөс хадаагүй боловч, ярианы хэлний халх аялгууны дуудлагын дагуу толгой үгийг кирилл үсгээр бичжээ. Харин Хятадад хэвлэгдсэн “Бүрэнтөгсийн толь”-д толгой үгийн бичгийн хэлний дуудлагыг хадаагүй ба “Хятадын нэг дэх хэвлэл”-д толгой үгийн ярианы хэлний дуудлагыг тэмдэглээгүйг эс тооцвол сүүлийн хоёр хэвлэлд бичгийн хэлний дуудлагыг латин галигаар, ярианы хэлний баримжаа авианы дуудлагыг олон улсын галигаар тус тус тэмдэглэжээ.

Монгол бичгийн зөв бичлэгийн тольд толгой үгийн бичгийн хэлний дуудлагыг хадах нь зөв бичлэгийн ёсон дахь авиа зүйн үндсэн зарчмын захирах хүчнийг гүйцэд ойлгоход туслахаар барахгүй, бичгийн хэлний үгийг бүрэлдүүлсэн үсэг, үе, бүтээврийн бүтэц хийгээд тэдгээрийн харилцан уялдах дүрмийг сурч хэрэглэхэд ихээхэн нэмэр болдог. Иймээс Монголд хэвлэгдсэн монгол бичгийн зөв бичлэгийн толь найруулагчид толгой үгийн бичгийн дуудлага хадах асуудлыг яасан ч олтгойлон орхигдуулж болохгүй.

Ормол үгийн гарал хийгээд бичлэгийн зөрөөнд илэрсэн Монгол Хятад хоёр улсын хэлний нөлөөллийн ялгаа. Хятадад хэвлэгдсэн тольд гол төлөв хятад хэлнээс зээлсэн ормол үгийг алдаг оног дагалдуулдаг боловч бичлэгийн дүрмийг хэлний төрлөөр нь ялгаж тодруулдаггүй. Харин Монголд хэвлэгдсэн тольд ихэвчлэн орос

хэлнээс зээлсэн ормол үгийг тусгай нэг төрлийн толгой үгээр төрөлжүүлж үндсэн үгтэй зэрэгцүүлэн жагсаасан бөгөөд монгол бичгийн үндсэн үгээс өвөрмөц байдаг бичлэгийн дүрмийг илүү нарийн тодруулсан байдаг. Монгол бичгийг эхэлж хэрэглэснээс одоо болтол монгол хэл бичиг судлаачид маш олон улс үндэстний хэлнээс шинэ үг, нэр томъёог авчирч орчуулах, үсэгчилж орчуулах аргаар ормол үгийг авч хэрэглэснээр монгол бичгийн хэлний үгийн сан баяжин харилцаа нэвтрэлцлийн чадвар нь тасралтгүй дээшилж байна. Энэ талаар Хятадын монгол бичгийн зөв бичлэгийн дүрмийг судлаачид судалгааны хүрээ хэвчээгээ тэлж, үндсэн үгийн бичлэгийн дүрмийг тогтолцоотойгоор судлахаас гадна ормол үг, тоо бичлэг мэтийн зөв бичлэгтэй холбоотой бүхий л асуудлыг хөндөн судлах талаар Монголын толь найруулагчдаас суралцвал зохино.

Үйл үгийг толгой үгээр жагсаахад тусгагдсан үгийн үндсийн бичлэгийг чухалчлах эсэхийн ялгаа. Монголд хэвлэгдсэн “Хадмал толь”-ыг эс тооцвол хоёр улсын монгол бичгийн зөв бичлэгийн толиудад үйл үгийг толгой үгээр жагсаахдаа “-ᠬᠠᠳᠮᠠᠯ [hɑ] -ᠲᠤᠯᠤ [hũ]” нөхцөлийг залгаж бичсэн байдаг. Үүнээс болж хоёр улсын монгол бичгийн хэвлэгдэхүүнд үндсээрээ хэрэглэгдсэн үйл үг (Жишээлбэл, нааш ир \ ᠨᠠᠶᠢᠷ [ir_e] \ . Бүрхүүлийг нь яр \ ᠶᠢᠷᠠ [ira] \ . Тэнд байгаа хар \ ᠬᠠᠷ [har_a] \ хувцас өмссөн хүнийг хар \ ᠬᠠᠷᠠ [hara] \ гэх мэт)-ийг бичихэд төвөгдөх эсвэл дүрэмжилгүй бичдэг үзэгдэл байнга тохиолдох болжээ. Зөв бичлэгийн толийн өвөрмөц онцлог нь үнэндээ монгол бичгийн хэлний бүх нэгжийн дангаар хэрэглэгдэх бичлэгийн дүрс ба хэлний бусад

нэгжтэйгээ харилцан уялдан хэрэглэгдэх үеийн бичлэгийн дүрсийг тодруулах явдал болно. Иймээс монгол бичгийн зөв бичлэгийн тольд толгой үг нь үйл үг байвал “Хадмал толь” дахь “зэрэглэ-¹ ᠵᠡᠷᠦᠭᠯᠡ/ ᠲᠡᠷᠦᠭᠯᠡ; зэрэглэ-² ᠵᠡᠷᠦᠭᠯᠡ/ : ᠵᠡᠷᠦᠭᠯᠡ ~; зэрэглээтэ- ᠵᠡᠷᠦᠭᠯᠡᠲᠡ; зэрэгцүүл- ᠵᠡᠷᠦᠭᠦᠯ; зэтгэ- ᠵᠡᠲᠭᠡ : ᠵᠡᠲᠭᠡ ᠵᠡᠲᠭᠡ; зээлэ- ᠵᠡᠭᠡᠯᠡ : ᠵᠡᠭᠡᠯᠡ ~; зээтүүд- ᠵᠡᠭᠡᠲᠦᠭᠦᠳ; ивлэ-¹ ᠶᠡᠯᠡ : ᠶᠡᠯᠡ ~; ивлэ-² ᠶᠡᠯᠡ : ᠶᠡᠯᠡ” (170 дугаар нүүр) гэх мэтчилэн бичсэн шиг “-ᠬᠠᠳ [hɑ] -ᠲᠤᠯᠤ [hũ]” нөхцөлөөр хувилгалгүй, уг үндсээр нь бичсэн толгой үгээр жагсаавал зохино.

Монгол бичгийн зөв бичих зүйн зарчим нь монгол бичгийн хэлний авианы зүйн зарчимд тулгуурлан үгийн зүйн зарчмаар дүрэмжиж, утгын зүйн зарчимд төлөвшин гарал зүйн зарчмаар баяжиж, өгүүлбэрийн зүйн зарчим ба эхийн судалгаагаар өргөжин тэлж олон улсын монгол ярианы хэлний хөгжлийг тэмдэглэж уламжлах үүргээ амжилттай биелүүлсээр байна. Монгол Хятад хоёр улсад хэвлэгдсэн монгол бичгийн зөв бичлэгийн толийг харьцуулсан судалгааны дүнд адилхан бичгийг хэрэглэж байгаа монгол хэлтнүүд адил бус улс оронд ажиллаж амьдарч байсан ч зөв бичлэгийн толь найруулах хэвшил нь нэгдмэл байж чадах аваас монгол бичиг нь сая соёлын өв тээгч, нэвтрэлцэл харилцааны гүүр болох үүрэг үйлдлээ нэн амжилттай гүйцэтгэж чадна.

Энэхүү өгүүлэл бол олон улсад ажиллаж амьдарч байгаа монголчуудын монгол бичгээ нэгдэлтэй бөгөөд дүрэмжилтэй хэрэглэж сайтар хөгжүүлэх зорилтоос Монгол, Хятад хоёр улсын адил бус цаг зайд хэвлэгдсэн монгол бичгийн зөв бичлэгийн толийн бар хэвлэлийн мэдээлэл ба толгой үг жич түүний тайлбарын найруулах арга барилд нөлөөлсөн нийгэм түүхийнх нь соёлын үнэт зүйлсийн чиг барим-

dictionary name in the copyright page, author, publication time, publication location, type of text, directory arrangement, orthography, appendix, reference, etc. The writing method includes nine aspects such as quantity, order, standard, type, part of

speech, explanation, indefinite "n", phonetic symbols, and loanwords.

Keywords: Traditional Mongolian orthographic dictionary; cultural value orientation, author, author biography, social status, responsibility.